| **2105** | **Нормативд зардал** | **59,094,500** | **58,631,600.00** | **462,900.00** | **99.22** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 51,817,500 | 51,817,500.00 | | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,602,000 | 6,139,100.00 | 462,900.00 | 92.99 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 675,000 | 675,000.00 | | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,600,700** | **15,245,300.00** | **355,400.00** | **97.72** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 5,150,700 | 4,921,800.00 | 228,900.00 | 95.56 |
| 210602 | Тавилга | 800,000 | | 800,000.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 683,000.00 | (683,000.00) | |
| 210604 | Урсгал засвар | 9,650,000 | 9,640,500.00 | 9,500.00 | 99.90 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,360,000** | **3,124,000.00** | **236,000.00** | **92.98** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,360,000 | 3,124,000.00 | 236,000.00 | 92.98 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,031,200** | **723,236.00** | **307,964.00** | **70.14** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000 | 540,000.00 | | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000 | 47,950.00 | 12,050.00 | 79.92 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,000 | | 148,000.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000 | | 99,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 34,200 | | 34,200.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 150,000 | 135,286.00 | 14,714.00 | 90.19 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,725,300** | **1,725,300.00** | | **100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,725,300 | 1,725,300.00 | | 100.00 |
| **83603** | **Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан** | **21,076,500** | **21,076,422.00** | **78.00** | **100.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **12,000,000** | | **12,000,000.00** | |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,000,000 | | 12,000,000.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21,076,500** | **21,076,422.00** | **78.00** | **100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,076,500** | **21,076,422.00** | **78.00** | **100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **21,076,500** | **21,076,422.00** | **78.00** | **100.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,000,000** | **3,999,930.00** | **70.00** | **100.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,000,000 | 3,999,930.00 | 70.00 | 100.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **15,000,000** | **14,999,992.00** | **8.00** | **100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 15,000,000 | 14,999,992.00 | 8.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,076,500** | **2,076,500.00** | | **100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,076,500 | 2,076,500.00 | | 100.00 |
| **3** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **9,076,500** | | **9,076,500.00** | |
| **30** | **Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого** | **8,767,800** | | **8,767,800.00** | |
| 300001 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 8,767,800 | | 8,767,800.00 | |
| **35** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **308,700** | | **308,700.00** | |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 308,700 | | 308,700.00 | |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **24,947,958.81** | | |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | **24,947,958.81** | | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

*2024 оны 12 -р сарын 31 өдөр* *|төгрөгөөр|*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **32,703,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **32,703,500.00** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **31,946,719.70** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,458,000.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,458,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **27,812,719.70** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,213,119.70 |
| 210302 | Түлш, халаалт | 25,549,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,676,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,676,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **756,780.30** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **756,780.30** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 756,780.30 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **32,703,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **32,703,500.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **32,703,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,703,500.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**<u>Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны</u>** ***<u>чиглэл:</u>***

Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр тэргүүлэгч эрүүл мэндийн төв болох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилт дэвшүүлсэн.
**Эрхэм зорилго:** Анхан шатны эмнэлгийн тусламжийг үйлчлүүлэгчийн хэрэгцээ , мэргэжлийн стандартад нийцүүлэн аюулгүй тав тухтай орчинд , тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхайрхан сумын эрүүл мэндийн төвийн *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Эрүүл мэндийн тухай хууль
2. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль

11. Төрийн хэмнэлтийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус төв нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн суурьиар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 328,490.1 мянган төгрөгөөр буюу 60.0 хувиар өссөн.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 13,322.57 | 128,889.9 | 115,567.33 |
| Бараа материал | 87421.4 | 113,227.96 | 25,806.56 |
| Үндсэн хөрөнгө | 369,598.49 | 382,451.6 | 12,853.2 |
| **Нийт хөрөнгө** | **470,651.2** | **649,517.5** | **178,866.3** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 453,344.88 | 633,979.3 | 180,634.42 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **470,651.2** | **649,517.5** | **178,866.63** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 13,322.57 мянган төгрөг, тайлант оны авлагын эцсийн үлдэгдэл 115,567.33 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 87,421.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 129,160.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 11,068.18 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 114,422.02 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 113,227.96 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,806.56 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 4,050.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 59,661.16 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогод авч, жилийн эцэст 649,517.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 50,858.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 180,634.42 мянган төгрөгөөр өсөж, тайлант онд өөрчлөлт орсон болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,048,768.6 мянган төгрөг, нийт зарлагыг 1,048,768.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 681,388.7 мянган төгрөгийг төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 656,790.12 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байна. Энэ нь цалин, НДШ-ийн зардал, бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардал тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | | |
| 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | **681,388.7** | **656,790.12** | **24,598.58** | **96.3** |
| 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 521,398.7 | 510,297.8 | 11,100.8 | 97.8 |
| 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 138,913.5 | 125,415.9 | 13,497.5 | 90.2 |
| 83603 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 21,076.5 | 21,076.42 | 0.078 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг бөгөөд нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг

санхүүжүүлж 31,946.7 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулж 756.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80109 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 32,703.5 | 31,946.7 | 756.8 | 97.7 |
| **НИЙТ** | | **32,703.5** | **31,946.7** | **756.8** | **97.7** |

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Харьцуулалтын арга | Эм, эмнэлгийн хэрэгсэл | 66,817.5 | 66811.5 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Хангамжийн зардал | 21,155.7 | 20,906.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалтын зардал | 25,549.1 | 25,549.1 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгааны зардал | 2,213.1 | 2,213.1 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр бохир усны зардал | 50.4 | 50.4 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Урсгал засварын зардал | 2,676.0 | 2,676.0 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Хоол хүнс | 6,602.0 | 6,139.1 |
| 8 | Шууд гэрээ байгуулах | Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардал | 15,600.7 | 15245.3 |
| **ДҮН** | | | **140,664.5** | **139,590.5** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны* 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 492,810.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,928.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,942.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төвд хийсэн завсрын аудитаар жолоочийн тооцооны хуудсаар шатахууны тооцоог бодохдоо авто машиныг эзэмшиж явсан албан тушаалтан ажлын тайлан бичиж хавсаргаагүй, өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зардлыг зөв ангилж бүртгээгүй зөрчилд 3 заалт зөвлөмж өгөгдсөнийг хугацаанд нь хэрэгжүүлж,2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 18 дугаартай тоотоор хариу ирүүлсэн байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллого хийгээгүй, хандиваар ирсэн Ланд-80 тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгэлд бүртгээгүй, үндсэн хөрөнгөд бүртгэлгүй тээврийн хэрэгсэлд авто сэлбэг худалдан авсан, 2022 оны жилийн эцсийн цалингийн урьдчилгааг суутгаж тооцоогүй 490,164.8 мянган төгрөгийн зөрчилд 5 заалт зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 5 | 490.164.8 | 5 | 490,164.8 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **490.164.8** | **5** | **490,164.8** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 115,248.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 заалт зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа: байхгүй**

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

**Илрүүлэлт**: Санхүүгийн тайланд өглөг үүсгээгүйгээр өмнөх оны 2,062.0 мянган төгрөгийн томилолтыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Төсвийг зохистой удирдаж, тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, төсвийн жил дамжуулан зарлага гаргахгүй байх;

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

**Илрүүлэлт**: Үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 113,186.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын

газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 115,248.0 мянган төгрөгийн зөрчлөөс 113,186.0 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэж, 2,062.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 113,186.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй | 1 | 113,186.0 | | | | | 1 | 113,186.0 | | | | |
| Өглөг үүсгээгүй урьд оны томилолтыг олгосон | 1 | 2,062.0 | | | | | 1 | 2,062.0 | | | | |
| **Дүн** | **2** | **115,248.0** | | | | | **2** | **115,248.0** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-24

АТА3366 9039376
0921100609

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24